



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 4-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ЖАВХЛАНБАЯР ТАНАА

2018.09.23 № 06/07
-ны № -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

133

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 4-Р СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70562112
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д. Оюунтуяа
Утас: 70562147
Цахим хаяг:

Аудитор: Ж.Болор-Эрдэнэ
Утас: 70562147
Цахим хаяг:

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТАБ-ын хаяг
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн
сум 3-р баг АЗДТГ-ын байр
Цахим хуудас:
Khentii@audit.gov.mn

2018 оны 02 дугаар сар

Байгуулга

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-018/162/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын гандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, өтөлбөрийн дагуу явуулав.

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга лэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн айдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Ж.Болор-Эрдэнэ эрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 25-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын гэгээрэлд гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт оруулсан байхгүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль “Хүүхэд бүрийг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадварт бие даан бүтээлчээр суралцах чадамжтай сурагч төлөвшүүлнэ” гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг гэгээрүүлж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн захирал Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн төрийн сангаас олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын горим, нарийвчилсан сорил 13 -г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

134

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед "их" гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 1301.3 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 1299.9 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 1.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд 2017 оны байгууллагын үйл ажиллагаа, төсөв хөрөнгийн талаарх мэдээллийг байршуулж, мэдээлбэл зохих мэдээллээс 29 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 13 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Тус байгууллага нь үндсэн хөрөнгийг актласан боловч устгалт хийх шийдвэр гаргаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн "оршин байх", "эрх ба үүрэг", "тохиолдсон байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. ЛАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй байна. Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данснаас 67.6 сая төгрөгийн хөрөнгийг актласан боловч байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл устгалт хийгээгүй нь СС-ын 2016 оны 131 дүгээр тушаал "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын заалтыг зөрчиж, "оршин байх", "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгийг данснаас хасаж устгалт хийхдээ байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл нь СС-ын 2016 оны 131 дүгээр тушаал "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-аар баталсан журмыг баримталж ажиллах талаар зөвлөмж өгөх

2. Багш, сурагчид, ажиллагсадын мэдлэг чадвар, мэргэжил, боловсролыг дээшлүүлэх зорилгоор 6 сургалтын төвтэй гэрээ хийж, 4.4 сая төгрөгийг шилжүүлсэн боловч, сургалтад хэдэн багш, сурагчид, ажиллагсад оролцсон талаар мэдээ тайлан, гүйцэтгэл, санхүүгийн баримтыг бүрдүүлээгүй байгаа нь "оршин байх", "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, НББ-ын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д заасан заалтыг баримтлан ажиллах талаар зөвлөмж өгөх.

3. Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллээс 29 мэдээлэлийг хугацаа хоцроож байршуулсан.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны мэдээллийг бүрэн үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулж, Шилэн дансны тухай хуулийн 4,6-р зүйлд заасан заалтыг баримтлан ажиллах талаар зөвлөмж өгөх.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг бус алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 72.0 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн ба дээрхи алдаа зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд "Ай Жэй Эй Эйч-Аудит" ХХК аудит хийсэн ба зөрчилгүй дүгнэлт өгсөн байна. Аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн ба тус байгууллага хугацаанд нь зөвлөмжийн биелэлтийг гаргаж, хүргүүлсэн байна. Зөвлөмж 100 хувь биелэсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ий өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан гэдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, хавсралтууд 4 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

	<u>Аудитын тайланг</u>	
<u>Хянасан:</u>	Дарга, Тэргүүлэх аудитор 	/ Ч.Эрдэнэбаатар/
	Аудитын менежер 	/ Д.Оюунтуяа/
<u>Бэлтгэсэн:</u>	Аудитор 	/ Ж.Болор-Эрдэнэ/



Огноо: 2018.02.14

энтий аймаг дахь Төрийн
аудитын газар

**ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 4-Р СУРГУУЛИЙН 2017
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:
Асуудал 1
Төсвийн зарцуулалт2

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг эгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд үүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын оримоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн анал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, сэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн захирал Б.Жавхланбаяр, нягтлан бодогч Д.Саруултуяа нарт талархал илэрхийлье.

АГ-ын ажиглалт

1. Үндсэн хөрөнгийн данснаас 67.6 сая төгрөгийн хөрөнгийг хасаж, актласан боловч байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл устгалтын шийдвэр гаргаагүй нь СС-ын 2016 оны 131 дүгээр тушаал "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын заалтыг зөрчсөн нь "оршин байх", "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Багш, сурагчид, ажиллагсадын мэдлэг чадвар, мэргэжил, боловсролыг дээшлүүлэх зорилгоор 6 сургалтын төвтэй гэрээ хийж, 4.4 сая төгрөгийг шилжүүлсэн боловч, сургалтанд хэдэн багш, сурагчид, ажиллагсад оролцсон талаар мэдээ тайлан, гүйцэтгэл, санхүүгийн баримтыг бүрдүүлээгүй байгаа нь "оршин байх", "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллээс 29 мэдээлэлийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, батлагдсан төсвийг хэтрүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх


АГ-ын зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийг данснаас хасаж, устгалт хийхдээ байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл нь СС-ын 2016 оны 131 дүгээр тушаал "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ыг баримталж ажиллах
2. Анхан шатны баримтын бүрдлийг хангаж, НББ-ын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д заасан заалтыг баримтлан ажиллах
3. Шилэн дансны мэдээллийг бүрэн үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулж, Шилэн дансны тухай хуулийн 4,6-р зүйлд заасан заалтыг баримтлан ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ



ЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

СЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ж.БОЛОР-ЭРДЭНЭ

Огноо: 2018.02.14